



Загийн бортоготой тарьцаар ойжуулалт хийх

Гандуу бүс нутагт загийн үрийг бортогонд ургуулж, ойгүй газрыг ойжуулах.

Энэхүү технологийг говь, цөлийн нөхцөлд заган ойг нөхөн сэргээх, нөөцийг нэмэгдүүлэх, хөрсийг тогтворжуулах зорилгоор хэрэгжүүлвэл зохистой юм. Үрийн ургац хангалттай жилд 0.3-0.4 өтгөрөлттэй ойн нэг га талбайгаас дунджаар 100-150 кг замбага түүнэ. Манай орны цөлийн хээр, цөлийн бүсэд 10-р сарын эхний хагаст загийн үрийн болц гүйцэнэ. Иймээс 10-р сарын дундаас 11-р сарын эхний хагаст үрийг түүнэ. Үрийн хольцын 40-45%-ийг дэвүүр, үлдэх хэсгийг мөчир, салмаа эзэлнэ. Иймээс заавал цэвэрлэх шаардлагатай. Үрийг сэврээсний дараа 3-4 мм-ийн нүхтэй шигшүүр буюу торон дээр хийж шигшинэ. Түүний дараа зөөлөн салхитай үед 1.3 м-ийн өндрөөс самарч унаган дэлбээг нь салхинд хийсгэж цэвэрлэнэ.

Загийн тарьц ургуулах бортого хийхэд 125-160 мк зузаантай нийлэг хальс тохиромжтой. Нийлэг хальсаар бортого эсгэхийн тулд 10.5 см өргөн, 25.5 см-ээс доошгүй урттай банз сарампай юмуу зузаан хатуу цаасаар эсгүүрийн загвар бэлтгэнэ. Бэлтгэсэн эсгүүрийн загварыг нийлэг хальсаар 50 хүртэл үеэр давхарлан орооно. Загвар модонд ороолттой нийлэг хальсны нэг талыг уртын дагуу зүсэж задгайлана. Ингэж задгайлсан хальсыг 25.5 см урттай тайрч бортогоо наахад бэлэн болгоно. Эсгэсэн нийлэг хальсны уртын дагуу голоор нь нугалж тал ба ёроолыг нь хайрч наалдуулахад 10.0-10.2 см голчтой 25.0-25.2 см өндөртэй цилиндр хэлбэртэй бортого болно. Загийн тарьц ургуулахад хөнгөн сийрэг бүтэцтэй элсэнцэр хөрс тохиромжтой бөгөөд бортогонд шороогоо дүүрэн хийвэл услах үед ус хальж асгардаг тул амсраас 2-3 см дундуур байх шаардлагатай. Тарьц ургуулах талбайг хавар 25-30 см гүн хагалж хагалгааны хөндлөн ба дагуу чиглэлд борнойдож тэгшилнэ. Үрийг тарихдаа цөлийн бүсэд 4-р сарын 15-аас 5-р сарын эхний 10 хоног, Цөлийн хээрийн бүсэд 4-р сарын сүүлчийн 20 хоногос 5-р сарын 15-ны хооронд байна. Загийн үрийг элсэн хөрсөнд 1.5-2.0 см, элсэнцэр хөрсөнд 0.5-1.0 см гүнд 2-3 ш үр суулгана. Шороогоор цэнэглэсэн бортуудыг 1 м өргөн 15-20 м урттай зайд эгнүүлэн өрж байрлуулана. Бортогонд үр суулгах, усалгаа, арчилгаа хийхэд тохиромжтойг бодож эгнээ хооронд 0,5-0,7 м зай үлдээнэ. Үр тарихын өмнө бортогны ёроолын шороог нортол буюу шороог нэвчтэл сайн услана. Нэг бортогонд 3-4 ширхэг үрийг 0,6-0,8 см гүнд суулгана үр тарьсны дараа усалгааг шүршүүрээр бороожуулан маш нямбай услах хэрэгтэй.

1-р зургийн тайлбар : Загийн бортоготой тарьцыг шилжүүлэн суулгасан заг

2-р зургийн тайлбар : Загийн бортоготой тарьц



Байршил: Дундговь аймгийн Өлзийт сумын Шар-Уул баг. **Технологийн хамрах хүрээ:** 10000 km²

Хөрс, ус хамгаалах арга хэмжээний төрөл: Ургамлын

Газар ашиглалтын төрөл:

Бэлчээрийн газар

Уур амьсгал: Хуурай, сэрүүн

MONCAT мэдээллийн сангийн нэрзүй: ТА МОН-06

Холбогдох арга барил: бүртгэгдээгүй

Технологийг нэвтрүүлсэн:

Ц.Бямбаа "Говийн төгөл" ХХК

Технологийн талаархи мэдээллийг өгсөн: Ц.Бямбаа

Технологийг бүртгэсэн:

А.Хауленбек, Л.Мөнхнасан,

Ц.Ганчөдөр

Он, сар, өдөр: 2008,09,14


Эмхэтгэгчдийн тайлбар: Заг нь говь цөлийн нөхцөлд дасан зохицсон онцгой ашигт модлог ургамал бөгөөд тарималжуулах, байгалийн нөхцөлд нөхөн сэргээх явдал нь нэлээд нарийн төвөгтэй байдаг. Бортогонд ургуулсан загийн тарьцыг байгальд шилжүүлэн суулгахад говийн ус чийг дутмаг нөхцөлд бие даан арчилгаа усалгаа шаардалгүйгээр ургадаг, элсний нүүдэл, салхины хүчийг бууруулан хөрсийг бэхжүүлдэг онцлогтой.

Ангилал

Газар ашиглалтанд тулгарч буй асуудал


Бэлчээрийг зохисгүй ашигласнаас газрын доройтлын үйл явцыг хурдасгаж байгаа нь ажиглагдсан. Иймээс доройтлыг бууруулахад бэлчээрийг зүй зохистой ашиглах шаардлагатай.

Газар ашиглалт



Өмнө нь бэлчээр технологи нэвтрүүлсний дараа хамгаалагдсан ой

Уур амьсгал



Хуурай

Доройтол




Биологийн доройтол: биомасс багасах



Салхины элэгдэл: Салхинд элэгдэх

Хамгааллын арга хэмжээ



Ургамлын: ойжуулалт

Техник үүрэг/үзүүлэх шууд нөлөө:


- Салхины хүчийг бууруулна
- Хөрсний элэгдэлийг багасгана
- Элсний нүүдлийг сааруулна
- Бэлчээрийн ургацыг нэмэгдүүлнэ
- Загийн тархац нутаг тэлнэ.

Техник үүрэг/үзүүлэх дам нөлөө:


- Хөрсний чийгийн агууламж нэмэгдэнэ
- Ургамлын төрөл зүйл нэмэгдэнэ

Байгаль орчин


Дундаж хур тунадас (mm)




Өндөршил (д.т.д м)




Гадаргын хэлбэр



Налуужилт(%)



Хөрсний гүн (см)



Ургамал ургалтын хугацаа: 130-151 өдөр

Хөрсний үржил шим: Дунд зэрэг

Хөрсний бүтэц: Бүдүүн ширхэгтэй

Гадаргын чулуурхаг байдал: Жижиг ширхэгтэй хайрга

Хөрсний гадаргын органик бодисын хэмжээ: Бага

Хөрсний ус нэвтрүүлэх чадвар: Сайн

Хөрсний элэгдэл, эвдрэлд өртөх байдал: Дунд

Агаарын жилийн дундаж температур: 0.9 C°.

Хамгийн их/бага температур: +36/-38

Агаарын хамгийн их/бага даралт:

11 сард 876.3 /мб/, 3сард 825.7 /мб/


Агаарын жилийн дундаж даралт: 854 /мб/

Нарны гийгүүллийн үргэлжлэх

хугацаа: Жилд 3080 цаг, 6-р сар буюу хамгийн ихдээ 304 цаг, 12-р сар буюу хамгийн багадаа 185 цаг байдаг байна.

Нийгэм-эдийн засаг

1 өрхөд ноогдох ногоон бүсийн хэмжээ (га)



Газар ашиглалтын эрх : Нээлттэй

Газар эзэмшсэн эсэх: Нийтийн/улсын

Зах зээлийн төрөлжилт: Холимог (амь зуулга /арилжаа наймаа)

Шаардагдах техник мэдлэгийн

түвшин: field staff/extension worker: дунд зэрэг


Хөдөө аж ахуйгаас олох орлого: 60%

Суурин/нүүдэлчин: Нүүдэлчин

Ядуурлын түвшин: Бага

Ажилгүйдлийн түвшин: Дунд

Нийгмийн зохион байгуулалт: Сайн



Техникийн зураг

Хэрэгжүүлэлтийн үе шат:

- Бортотог бэлдэх
- Хөрс бэлдэх
- Үр суулгах
- Ойжуулалт хийх

Хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хөрөнгө оруулалт, үнэ өртөг

Үүсгэн байгуулах үйл ажиллагаа	Зардал, үнэ өртөг Материал	Үнэ (US\$)	Газар ашиглагчаас гарах %
1. Үрээ цуглццлана (10-р сарын сүүлчээр)			
2. Түүж бэлтгэсэн үрээ цэвэрлэнэ	ҮР/ 3 кг нь 20000₮/кг	60	0%
3. Үрээ хадгална	Элс /3.5 тонн нь 5000₮/тонн	17.5	0%
4. Бортотог бэлдэнэ	Хар шороо / 1 тонн нь 5000₮/тонн	5	0%
5. Хөрсний холимогоо бэлдэнэ (Хөрсний холимогийг of 70 хувь нь элс, 20 % хар шороо, 10 % нь бордоо байхаар бэлдэнэ)	Бордоо / 0.5 тонн нь 2500₮/тонн Бэлтгэсэн бортотог өрөх / 1000ш, 1 бүрийн үнэ 20 ₮/ Эхний усалгаа/1000ш, 1 бүрийн үнэ 3₮	2.5 20 3	0% 0% 0%
6. Бортогыг хөрсөөр дүүргэж, услана	Тарих/1000ш, 1 бүрийн үнэ 3₮	3	0%
7. Бортыг мод үржүүлгийн газарт байрлуулна	Ургалтын үеийн усалгаа	40	0%
8. Бортогонд үрээ тарина	Бортогонд ургасан хог ургамлыг түүх, сийрүүлэх	12	0%
	Ойжуулах зардал		0%
	Тээвэрлэлт / 1000ш, 1 бүрийн үнэ 25₮/	25	0%
	Анжис болон жоотуугаар зурвас гаргах / 1000ш, 1 бүрийн үнэ 35 ₮	35	0%
	Бортоготой тарьцыг суулгах /1000ш, 1 бүрийн үнэ 30 ₮	30	0%
	Бортог / 1 га-д 1000ш, 1 бүрийн үнэ 45 ₮	45	0%
	НИЙТ	568	0%

Хүн хүчний өртөг Бусад хөрөнгө оруулалт

Өндөр	Өндөр
Дунд	Дунд
Бага	Бага

Тогтмол хийгдэх үйл ажиллагаа	Урсгал зардал /1 жилд га-аар/ Гарах зардал	Үнэ (US\$)	Газар ашиглагчаас ас гарах %
1. Нөхөн сэргээлт хийх	Нөхөн сэргээлт хийх	55	0%
	Нийт	55	0%

Үнэлгээ

Үр ашиг/газар ашиглагчаас хамаарсан өртөг	Газар ашиглагчийн үзэж байгаагаар олсон ашиг	Богино хугацаанд	Урт хугацаанд
	Анх байгуулахад зарцуулагдсан зардалтай харьцуулахад олсон үр ашиг	Сөрөг	Тодорхойгүй
	Урсгал зардалтай харьцуулахад олсон үр ашиг	Маш сөрөг	Тодорхойгүй

Технологийн нөлөөлөл	
Бүтээгдэхүүн болон нийгэм эдийн засгийн үр ашиг + + <input type="checkbox"/> Модны төрөл нэмэгдсэн	Бүтээгдэхүүн болон нийгэм эдийн засгийн алдагдал <input type="checkbox"/> үгүй
Нийгэм соёлын үр ашиг + + <input type="checkbox"/> Хамгаалал доройтлын талаарх мэдэлэг нэмэгдсэн	Нийгэм соёлын алдагдал <input type="checkbox"/> үгүй
Экологийн үр ашиг + + + Хөрсний өнгөн давхарга сайжирсан + + + Хөрсний чийг нэмэгдсэн + + + Биомасс нэмэгдсэн + + + Хөрсний үржил шим сайжирсан	Экологийн алдагдал <input type="checkbox"/> үгүй
Дам үр ашиг + + + reduced downstream flooding	Дам сул тал <input type="checkbox"/> үгүй

Давуу тал ба/буюу → хэрхэн тогтвортой байлгах/сайжруулах	Сул тал ба/буюу → хэрхэн даван туулах
Ойжуулахад маш хямд өртөгтэй, үр өгөөжтэй аргын → тус технологийг доройтсон өөр бүс нутагт нэвтрүүлэх Заг мод нь хуурай газарт дасан цохицох, ургах чадвартай бөгөөд байгалийн чийгээр ургадаг хуурай болон маш хуурай бүсд доройтсон газрыг нөхөн сэргээх зорилгоор → загийн үржүүлгийн газрыг ихээр байгуулах	Технологийн арга техник төвөгтэй → Мэргэжлийн их дээд сургуулиуд болон орон нутгийн түвшинд хуурай бүс нутгийг ойжуулах сургуулыг идэвхижүүлэх Ойжуулах болон шилжүүлэн суулгалтыг хийх тээврийн зардал өндөр → тухайн ойжуулах ажлыг хийх газрын ойролцоо бортогонд үрийш суулгах ажлыг дэмжих

Холбоо барих байгууллага: ШУА-ийн Газаргүй - Геоэкологийн хүрээлэн: Цөлжилтийн судалгааны салбар
Утас: 976-11-325487 **Факс:** 976-11-322187
Вебсайт: www.igg.ac.mn, www.geo-eco.mn